



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хотонт сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/115/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Утас: 703333019 Цахим хаяг: soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

Г ХОТОНТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА О.ЭНХЧИМЭГ ТАНАА

2022.02.15 № 10
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хотонт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Т.Байгалмаа* Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,262,241.00	14,399,941.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,262,241.00	14,399,941.00
35400	Хангамжийн материал	14,262,241.00	14,399,941.00
35410	Бичиг хэргийн материал	13,812,241.00	13,812,241.00
35440	Түлш, шатах тослох материал	450,000.00	587,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	148,113,548.89	1,284,973,016.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	148,113,548.89	1,284,973,016.82
39200	Биет хөрөнгө	144,173,548.89	1,281,033,016.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	101,540,017.59	1,198,898,870.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,638,253.81	-3,892,727.60
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,311,359.00	10,257,909.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,311,359.00	-3,294,642.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,144,724.64	38,594,545.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,226,505.53	-13,884,503.56
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	33,667,750.00	33,667,750.00
39217	Ном	20,685,816.00	20,685,816.00
39300	Биет бус хөрөнгө	3,940,000.00	3,940,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,940,000.00	3,940,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	162,375,789.89	1,299,372,957.82
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	162,375,789.89	1,299,372,957.82
51	Засгийн газрын хувь оролцоо	162,375,789.89	1,299,372,957.82
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	96,124,405.00	96,124,405.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,010,515.60	1,200,187,687.97
51210	Өмнөх үеийн үр дүн	6,607,401.28	63,190,520.04
51220	Тайлант үеийн үр дүн	-4,596,885.68	1,136,997,167.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,240,869.29	3,060,864.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	162,375,789.89	1,299,372,957.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	134,240,800.00	1,368,389,741.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,224,795,241.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,224,795,241.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1,224,795,241.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	1,224,795,241.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	134,240,800.00	143,594,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	134,240,800.00	143,594,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	134,240,800.00	143,594,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	138,837,685.68	148,569,468.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,837,685.68	148,569,468.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,913,385.68	131,113,453.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,832,600.00	93,276,166.00
210101	Үндсэн цалин	69,832,600.00	93,276,166.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,427,400.00	11,819,919.00
210201	Тэтгэврийн даатгал	6,634,100.00	8,190,699.00
210202	Тэтгэмжийн даатгал	698,300.00	932,861.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	558,700.00	746,567.00
210204	Ажилгүйдлийн даатгал	139,700.00	175,226.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,396,600.00	1,774,566.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,150,000.00	11,299,300.00
210301	Гэрэл, цахилгаан	705,350.00	3,382,288.00
210302	Түлш, халаалт	5,344,650.00	7,697,012.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	220,000.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	660,920.00	1,115,500.00
210401	Бичиг хэрэг	176,520.00	226,000.00
210402	Тээвэр, шатахуун	266,900.00	390,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	58,200.00	314,000.00
210404	Ном, хэвлэл	42,000.00	66,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	117,300.00	119,200.00
2105	Нормативт зардал	49,600.00	74,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,600.00	74,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,500.00	127,500.00
210702	Дотоод албан томилолт	70,500.00	127,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	533,000.00	2,688,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	320,000.00	2,422,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	133,000.00	145,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,089,365.68	10,612,668.43
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,089,365.68	10,612,668.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,924,300.00	17,456,015.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,924,300.00	1,761,500.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,624,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	1,761,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	15,694,515.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	15,694,515.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-4,596,885.68	1,219,820,272.57
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	82,823,104.64
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	82,823,104.64
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,596,885.68	1,136,997,167.93

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,124,405.00	64,240,869.29	6,607,401.28	166,972,675.57
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,124,405.00	64,240,869.29	6,607,401.28	166,972,675.57
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,596,885.68	-4,596,885.68
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,124,405.00	64,240,869.29	2,010,515.60	162,375,789.89
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	96,124,405.00	64,240,869.29	2,010,515.60	162,375,789.89
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	61,180,004.44	61,180,004.44
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,124,405.00	64,240,869.29	63,190,520.04	223,555,794.33
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	61,180,004.44	0.00	-61,180,004.44
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,136,997,167.93	1,136,997,167.93
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	96,124,405.00	3,060,864.85	1,200,187,687.97	1,299,372,957.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	134,240,800.00	143,594,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	134,240,800.00	143,594,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	134,240,800.00	143,594,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	134,240,800.00	143,594,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	134,240,800.00	138,094,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	134,240,800.00	138,094,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,316,500.00	120,638,485.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,832,600.00	93,276,166.00
210101	Үндсэн цалин	69,832,600.00	93,276,166.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,427,400.00	11,819,919.00
210201	Тэтгэврийн даатгал	6,634,100.00	8,190,699.00
210202	Тэтгэмжийн даатгал	698,300.00	932,861.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	558,700.00	746,567.00
210204	Ажилгүйдлийн даатгал	139,700.00	175,226.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,396,600.00	1,774,566.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,600,000.00	11,437,000.00
210301	Гэрэл, цахилгаан	705,350.00	3,382,288.00
210302	Түлш, халаалт	5,794,650.00	7,834,712.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	589,000.00	1,115,500.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	240,000.00
210402	Тээвэр, шатахуун	266,900.00	390,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,200.00
2105	Нормативт зардал	49,000.00	74,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	74,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,500.00	127,500.00
210702	Дотоод албан томилолт	70,500.00	127,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	2,688,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	145,500.00	145,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,924,300.00	17,456,015.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,924,300.00	1,761,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,624,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	1,761,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	15,694,515.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	15,694,515.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	5,500,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	5,500,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	5,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	5,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	5,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-5,500,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	143,594,500.00	127,899,985.00	15,694,515.00	89.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	143,594,500.00	127,899,985.00	15,694,515.00	89.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	141,833,000.00	126,138,485.00	15,694,515.00	88.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106,423,400.00	93,276,166.00	13,147,234.00	87.65
210101	Үндсэн цалин	106,423,400.00	93,276,166.00	13,147,234.00	87.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,367,200.00	11,819,919.00	2,547,281.00	82.27
210201	Тэтгэврийн даатгал	10,110,300.00	8,190,699.00	1,919,601.00	81.01
210202	Тэтгэмжийн даатгал	1,064,200.00	932,861.00	131,339.00	87.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	851,400.00	746,567.00	104,833.00	87.69
210204	Ажилгүйдлийн даатгал	212,800.00	175,226.00	37,574.00	82.34
210205	Эрүүл мэндийн даатгал	2,128,500.00	1,774,566.00	353,934.00	83.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,437,000.00	11,437,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	6,217,000.00	3,382,288.00	2,834,712.00	54.40
210302	Түлш, халаалт	5,000,000.00	7,834,712.00	-2,834,712.00	156.69
210303	Цэвэр, бохир ус	220,000.00	220,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,115,500.00	1,115,500.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	240,000.00	240,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	390,000.00	390,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,200.00	119,200.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	74,400.00	74,400.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	74,400.00	74,400.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	127,500.00	127,500.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	127,500.00	127,500.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,688,000.00	2,688,000.00	0.00	100.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	120,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	145,500.00	145,500.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,761,500.00	1,761,500.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,761,500.00	1,761,500.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,761,500.00	1,761,500.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	143,594,500.00	127,899,985.00	15,694,515.00	89.07
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	143,594,500.00	127,899,985.00	15,694,515.00	89.07
320001	Орон нутгийн төсвөөс	143,594,500.00	127,899,985.00	15,694,515.00	89.07
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	17	17	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	8	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хотонт сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Хотонт сумын Соёлын төв нь өв уламжлалаа сэргээн хадгалж, иргэдийн соёлын хэрэгцээг хангаж оюуны болон гоо зүйн боловсрол олгодог тэргүүний соёлын төв болох зорилготой соёл урлагын үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн төсвөөс санхүүждэг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд Хотонт сумын иргэдийн соёлын хэрэгцээг хангаж, соёлын үйл ажиллагааг тогтмол, хүртээмжтэй хүргэх, хүүхэд залуучуудад гоо зүйн боловсрол олгох, хүн төрөлхтөний соёлын хосгүй үнэт болох соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, иргэдэд соёл урлагын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилтыг тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсон байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний

"9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй" гэснээр даатгуулагч болон ажил олгогчоос төлөх НДШ тус бүр 1%-аар буурч өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагаанд санхүүгийн гүйлгээ, мэдээллийг шилэн дансанд тухай бүр байршуулсан талаар, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын талаар хяналт хийж ажилласан байна.

Хотонт сумын Соёлын төв нь Архангай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад эрх бүхий байгууллагаас болон хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хотонт сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 143.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1137.0 сая төгрөгөөр буюу 700.6 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	14.2	14.4	0.2	1.4
Үндсэн хөрөнгө	148.1	1284.9	1136.8	767.6
Нийт хөрөнгө	162.3	1299.3	1137.0	700.6
Өр төлбөр	-	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	162.3	1299.3	1137.0	700.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	162.3	1299.3	1137.0	700.6

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 1.4 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 14.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 11.8 төгрөг нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 11.7 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 14.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 767.6 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 177.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 5.5 сая төгрөгөөр ЛОКА ХХК-аас тавилга, эд хогшилыг төсвийн хөрөнгөөр худалдаж авсан, Соёлын яамнаас 17.9 сая төгрөгийн тавилга, эд хогшил, Соёл урлагийн газраас 7.9 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан. Соёлын төвийн 240 хүний суудалтай шинэ барилгыг Хатант констракшн ХХК-аас хүлээн авч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 35 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 461 тоот албан бичгээр зөвшөөрөл олгосны дагуу данс бүртгэлд нэмж авсан бөгөөд нийт 1230.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, аймгийн ОНӨГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 12 тоот албан бичгээр байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн зөвшөөрөл олгосны дагуу 101.5 сая төгрөгийн Соёлын төвийн хуучин барилгыг хашааны хамт үндсэн хөрөнгийн данснаас хасч, тайлант хугацаанд байгуулсан 21.1 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 1284.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр данс нь тайлант хугацаанд өр авлагагүй ажилласан байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 1137.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/ төгрөг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	134.24	143.59	9.35
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00	0
Татварын бус орлого	0.00	1,224.79	1,224.79
Үйл ажиллагааны орлого	134.24	1,368.38	1,234.14
Цалин, шимтгэлийн зардал	79.26	105.09	25.83
Бусад бараа үйлчилгээний зардал	51.95	30.17	-21.78
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.53	2.68	2.15
Бараа үйлчилгээний бусад зардал	7.08	10.61	3.52
Үйл ажиллагааны зардал	138.83	148.56	9.73
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-4.59	1,219.82	1,224.41
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	82.82	82.82
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4.59	1,136.99	1,141.59

Хотонт сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 1234.1 сая төгрөгөөр буюу 919.3 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө /Соёлын төвийн шинэ барилга/ нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд 2021 онд батлагдсан зардлыг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 117.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 25.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 143.5 сая төгрөгөөр хянаж баталсан бөгөөд энэ нь 2021 онд батлагдсан орон тоо 12 болж, 4 орон тоогоор нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 143.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 143.5 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 127.9 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 15.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 15.6 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд “Ковид 19” цар тахалтай холбоотойгоор соёлын үйлчилгээ, олон нийтийн ажлыг хориглосон тул нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус соёлын төв нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед улс, аймаг сумын онцгой комиссоос аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны дагуу соёл урлагийн үйлчилгээг хориглосны улмаас соёл урлагийн болон олон нийтийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Страдын дууны цахим уралдаан
- “Миний гэр бүлийн аз жаргал” фото зургийн уралдаан
- “Цахимаар шинэлье” уриан дор сумын нийт төрийн албан хаагч, иргэдийн дунд Ардын дууны цахим тэмцээн
- “Ээждээ захидал бичээрэй” цахим захидлын уралдаан
- “Аавдаа шүлэг бичээрэй” цахим уралдаан зэрэг нийт 11 арга хэмжээг зохион байгуулж, 705 хүн хамрагдсан байна. Мөн Номын сангаар 1530 уншигч үйлчлүүлж, 780 ном хэвлэлийг уншлаганд гаргасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 83.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 143.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 127.9 сая төгрөгийг зарцуулж, 89.0 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтан байхгүй.

- Урсгал зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2. Суудлын автомашингүй.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгалаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хотонт сумын Соёлын төв нь тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийг шалгахад нийт 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээллэсэн, мөн 13.3 сая төгрөгийн 6 орлогын, 13.3 сая төгрөгийн 6 зарлагын нийт 26.6 сая төгрөгийн 12 гүйлгээг Шилэн дансны цахим хуудаст ил тод бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд батлагдсан төсвөөс 5.5 сая төгрөгийн буюу 24.1 хувийн хэмнэлтийг бий болгосон.

Харин тус хэмнэлтийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн Хотонт сумын Соёлын төвийн 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 8 тоот албан хүсэлтийн дагуу Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр

сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан тодотгосон төсвөөр хөрөнгийн зардалд хуваарилж баталж өгснөөр тавилга, эд хогшил худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 43-р тогтоолын 1.4-д заасан “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах **албан шаардлагыг** хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн тувшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд 44.6 сая төгрөгийн тэтгэмжийн гүйлгээг байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг таслан зогсоож ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг анхан шатны баримтад үндэслэн нарийвчлан шалгана.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1224.7 сая төгрөгийн алдаа илэрснийг залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд 1224.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогоор тусгуулан залруулга хийлгэлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хотонт сумын Соёлын төв	1	1224.7	1	1224.7	0	0	0	0	0	0
Дүн		1	1224.7	1	1224.7		0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хотонт сумын Соёлын төв	1	5.5	0	0	0	0	1	5.5	0	0
Дүн		1	5.5	0	0	0	0	1	5.5	0	0
Нийт дүн		2	1230.2	1	1224.7	0	0	1	5.5	0	0